

УЛС ТӨРИЙН ШОГИЙГ УХААН САНАА ЗАРЖ, УР ЧАДВАР ЗААЖ
БИЧДЭГ ЮМ

(Номын шүүмжээс хэсэгчлэн нийтлэв)

Т.Баасансүрэн*

*Сэтгүүл зүй судлаач, доктор (Ph.D), профессор

Түлхүүр үг: памфлет, сэтгүүлчийн ур чадвар, “Гол тоглогч”, зохиомж.

Учирлан тайлбарлах нь. Монголын сэтгүүл зүйн бичлэгийн төрөл, зүйл дотор хэн ч барьж авч зүрхлэхгүй дөлж зугтсаар эдүгээг хүргэсэн нэг жанр байсан юм. Энэ бол памфлет. Нэг намын системтэй социализмын он жилүүдэд үүнийг ойлгож болох байлаа. Ардчилсан, олон ургальч үзэл дэлгэрсэн, чөлөөт хэвлэлүүд өрсөлдсөн сүүлийн гучаад жилд ч уг жанраар манайд бичих хүн байсангүй. Фельетон бичдэг цорын ганц хүн төрсөн нь Б.Цэнддоо байлаа.

Бусад улс оронд бол түгээмэл байдаг памфлетыг манайхан яагаад барьж авч чаддаггүйн учир шалтгааныг судлаачид тайлбарлах байх. Харин би уг бичлэгийн талаарх товч ойлголтыг эхлээд уншигчдад өгье. Памфлетыг монгол хэлнээ “улс төрийн шог” гэж орчуулжээ. Нэг их тод бус ч жанрыг зүйл гэж орчуулснаас арай дээр сонсогдож байна. Грек үг. Ратта буюу “бүгдийг”, рlegо буюу “шатаах, устгах” гэсэн үгнээс үүсэлтэй гэнэ. Улс төрийн хурц мэтгэлцээний нэг чухал арга

агаад сэтгүүл зүйн бичлэгийн нэг хэлбэр юм.

Улс төрийн шогт дайрч давшилсан мэт шинж тэмдэг илэрхий мэдрэгдэнэ. Ёжлон ёгтолсон өнгө аястай, адилтгал зүйрлэл, ихэсгэл багасгалыг өргөн хэрэглэнэ. Товч тодорхойг эрхэмлэнэ. Шоглол дээд зэргээр илрэн гарах бөгөөд хурц хэллэгтэй, аянга нижигнүүлж, цахилгаан гялбуулсан “хилэнт үгс”-ээр халгиж бялхсан, тэгсэн атлаа уран дүрслэлтэй, уншууртай сонирхолтой байна. Элэглэл, дооглол, ёгтлолоор элбэг баян, хэтрүүлэл егөөдлөөр зай завсаргүй шаглаж чимхэлж имэрдсэн байдаг.

Дэлхийн улс орнуудын утга зохиол, сэтгүүл зүйн түүх, практикаас харахад улс төрийн шог буюу памфлетыг нийгмийн байгууллыг бүхэлд нь буруушаан шүүмжлэх буюу улс нийгмийг удирдаж буй урагшгүй албатууд, тэдний үнэн нүүр царайг илчлэн үзүүлэхэд байнга ашиглаж иржээ. Памфлет гэдэг үг нь “бүгдийг бүрэн няцааж, шатааж устгах” гэсэн үгнээс гаралтайг бүү мартаарай. Монголын нийгмийн толгойд бөгс бөөрөөрөө нийлж нэгдэн, хэтэвч түрийвчээрээ холбогдож гагнагдсан олигархи бүлэглэлүүд ид эрч хүчээ аван

дураараа дургиж дунд чөмгөөрөө жиргэж буй эгзэгтэй өнөөгийн цаг үед памфлет бичдэг сэтгүүлч төрөн гарч ирж буйг би хувьдаа санамсаргүй тохиолдол гэж бодохгүй байна.

Английн хөрөнгөтний хувьсгалын үед нэрт соён гэгээрүүлэгчдийн нэрт төлөөлөгчид, тухайлбал Дж.Мильтон, Д.Дефо, Дж.Свифт нар улс төрийн шогийг бичиж нийгмийн бурангуйтай шаргуу тэмцэж байв. Ф.Энгельс 1842 онд “Христосын философич Шелленг буюу амьдралын ухааныг бурхны ухаанд хувиргасан нь”, К.Маркс 1852 онд “Луй Бонапартын брюмерийн арван найман”, “Капиталын шашин” зэрэг алдарт памфлетаа бичиж байв.

Пролетарийн их зохиолч гэгддэг М.Горький 1906 онд “Оросын хаан”, “Шар шулмасын хот” хэмээх улс төрийн шогоо туурвиж Оросын нийгмийн хоцрогдол, хаан болоод бусад ихэс дээдсийн арчаагүй байдлыг илчлэн шүүмжилж байжээ.

Памфлет бол зохиогчийн эсэргүүцэл тэмцлээ илэрхийлэх хамгийн хурц дайчин бичлэгийн аргын нэг юм. Нийгэмд оршин буй муу муухай зүйл, үзэгдэл юмстай эвлэршгүй байх үүднээс эсэргүүцэн босч дургүйцэн бичиж буйн нэг илэрхийлэл болно. Нийгмийг буруу зүг рүү буйллан чангааж байгаа, улс нийгэм, ард түмнээ бус зөвхөн өөрсдийгөө бодон хувиа бодож довоо шарлуулж байгаа урагшгүй удирдагчид, улс төрчидтэй үгийн зэвсгээр үзэлцэж байгаа нэг хэлбэр юм. Сэтгүүлчийн мэргэжил бол тэмцэгчийн мэргэжил мөн гэж хүн төрөлхтөний суут ухаантнууд зүгээр ч нэг хэлээгүй нь эндээс илүүтэй тод мэдрэгдэнэ. Агуулгын хувьд ер бусын хүчтэй эсэргүүцэл бүхий байх бөгөөд бузар булайг уг үндсээр нь уудлан илчлээд түүнийгээ шээс алдам

хэтэрхий хурц үг хэллэг, ам ангайм адилтгал зүйрлэлээр тодотгон товойлгож үзүүлээд элэг хөшим хэмжээнд элэглэн дооглож, ёгтлон ёжлох нь сэтгүүл зүйн памфлет хэмээх бичлэгийн үндсэн төрөлх шинж чанар нь юм. Ийм ур чадварыг эзэмшинэ гэдэг тун бэрх, бараг байхгүй. Өдрийн од шиг ховорхон. Гайхалтай нь Монголын сэтгүүл зүйд тийм зоригтой, тэнгэрлэг золбоотон төржээ. Одоо тэрхүү сэтгүүлч буюу Дамдинсүрэнгийн Дамдинжавын “Гол тоглогч” номын жишээн дээр баримт түшиж өгүүлье.

Гол тоглогчдоор хэн хэнийг тодруулав.

“Гол тоглогч” ном 2018 оны 5-р сард хэвлэгдэж уншигчдын гарт хүрсэн. Уг номд “Женко”, “Сүүлчийн гавьяат “жүжигчин”, “Манай үеийн мангас”, “Хүн зуудаг “хоточ”, “Хүйтэн цуст” капиталист”, “Зэлтэрийн гацааны Зи “пацаан”, “Хүнд жингийн “Коммунист”, “Нохой шуугиулсан баатар”, “Монголоо мандуулсан маршал”, “Хашин бэрс”, “Зайлшгүй сайд”, “Поп”-ын хаан” зэрэг 16 памфлет ба хөрөг оржээ. Халтмаагийн Баттулга, Цахиагийн Элбэгдорж, Намбарын Энхбаяр, Цэндийн Нямдорж, Сүхбаатарын Батболд, Зандаахүүгийн Энхболд, Ухнаагийн Хүрэлсүх, Херо Баатар, Хорлоогийн Чойбалсан, Гомбожавын Занданшатар, Жадамбын Энхбаяр, Сайнхүүгийн Ганбаатар нарын улс төрч, зарим уран бүтээлчийн тухай бичжээ. Сүүлийн гучин жилд Монголын төр засгийн эрх мэдлийг гартаа атгаж, улс орны эдийн засгийн хөгжлийг залж чиглүүлэх, ард түмний аж амьдралыг дээшлүүлэх буюу дошлуулах үйлсэд ямар нэг байдлаар оролцож, үүрэг хариуцлага хүлээж ирсэн эрхмүүдийг нээн үзүүлэх гэж оролдсон бололтой.

Гэхдээ гүйцэд биш аж. Энэ тухай сүүлд жич өгүүлнэ.

Үг хэллэг хурц бөгөөд дайчин давшингүй, адилтгал зүйрлэлээр элбэг баян агаад тэдгээр нь ончтой оновчтой, ёгтлол ёжлол хийгээд элэглэл инээдмээр дүүрэн, дүр дүрслэл нь сонин ба сонирхол татахуйц уншууртай ном болсныг юуны өмнө онцлон тэмдэглэе. Одоо ийнхүү тодорхойлноо Д.Дамдинжавын тодорхой бүтээлүүдийн жишээн дээр нотолж батлах гэж оролдъё.

“Женко” хэмээх улс төрийн шогийг “Женко хэрхэн төрсөн бэ?”, “Женко” яаж баяжсан бэ?”, “600 сая төгрөгтэй “сейф”-ийг 44 саяар худалдаж авсан түүх”, “17 чингэлэг спиртийг ус болгож чадсан түүх”, “Женко” гэх вант улс”, “Мафи маягийн улс төр”, “Өөрийн нохой”, “Өрөөлийн нохой”, “Олигархи”, “Дуулиан”, “Жинхэнэ гавьяа”, “Хэвлэлийн гал цогтой гигант”, “Жинхэнэ “HERO”, “Ганцаардсан чоно”, “Женко” хэрхэн төгсөх бол?” гэсэн 15 жижиг гарчигт хувааж асуулт ба түүндээ өгсөн хариулт хэлбэрээр бичсэн аж. Жишээ нь “17 чингэлэг спиртийг ус болгож чадсан түүх” хэмээх гарчигтай бичлэгт “1997 онд Монгол Улсын хилээр төмөр замаар 17 чингэлэг ачаа орж ирсэн нь 340 тонн спирт болох нь илэрч баригджээ. Энэ хэрэгт “Женко” группийн эзэн Х.Баттулга, “Нарантуул” захын эзэн Ш.Сайхансамбуу, Улсын арслан Д.Мөнх-Эрдэнэ тэргүүтэй нэр бүхий хүмүүсийг шалгасан байдаг... 1997 оны 10-р сарын 5-ны шөнө тухайн үеийн УИХ-ын гишүүн асан С.Билэгсайханы нэр дээр бүртгэлтэй “Билэг” гаалийн баталгаат агуулахын хяналтын талбайд битүүмжлэгдэж хадгалагдаж байсан 17 чингэлэг спирт гэнэт усаар солигдсон байж. Хилээр

орж ирсэн 17 чингэлэг спиртийг ус, ариутгалын бодис хэмээн гаалийн бүртгэлд хуурамчаар оруулсан баримтыг Монголын үндэсний телевизийн сэтгүүлчид тухайн үед хальсандаа буулгасан байсан боловч харамсалтай нь тэр бичлэг мөн ижил цаг хугацаанд хулгайлагдсан. Бичлэг алдагдсан хэрэгт сэтгүүлч Д.Төрмөнх холбогдож байсан нь бас сонин. Тэрээр бичлэгийг Х.Баттулгад хулгайлан авч өгсөн үндэслэлээр хэсэг хугацаанд хоригдож байсан түүхтэй.

Алдарт энэ хэргээс болж, манай гол баатар Монголдоо ирэхээс эмээж, олон сараар гадаадад амьдарсан нь бодит үнэн. Монголд түүнийг интерполоор эрэн сурвалжилж байх үед тэр Түвдэд мөргөл үйлдэн, Хонконгод 6 сар орчим орогножээ. Хэрвээ Ц.Элбэгдорж байгаагүй бол Х.Баттулга дээлээ нөмрөөд дуусах байсан ч гэж яригддаг... Энэ үеэс тэдний нөхөрлөл илэрхий зузаарсан нь бас бодит юм. Онцгой албан татваргүй 340 тонн спирт ийнхүү маш нууц операцийн дор монголчуудын ходоод руу цутгасан гэж болно. Яг тэр үед Женкогийн хөрөнгө 10 дахин нугарсан байх магадлалтай. Тэр энэ үеэс л бусдаасаа тасарч, Монголын тэргүүн баян болж чадсан байдаг... Улс төр, эрх мэдэлгүйгээр ямар ч мөнгө цаас болж хувираад салхинд хийсч магадгүйг тэр ойлгожээ. Яг спиртийг ус болгож чадсан тэрхүү ид хав, эрх мэдлийг өөрөө эзэмшихийг хүсч байлаа” гэх зэргээр бичсэн байна.

Үүнийгээ БНН-ын дарга Б.Жаргалсайханы хэлсэн “Тэр хувийн цагдаатай, тагнуулчтай, прокурортой, шүүгчтэй, өөрийн харъяаны сайн эрс, гэмт хэрэгтнүүдтэй, намтай, улс төрчидтэй, хэвлэл, радио, телевизтэй. Түүнд байхгүй юм байхгүй” гэсэн үгээр баталгаажуулан шигтгэж өгчээ. 15

гарчиг тус бүрт хэн нэгний Женкогийн тухай онож хэлсэн ончтой үгийг ишлэж татсан аж. Жишээ нь “Х.Баттулга бол нохой. Гэхдээ хүний биш, өөрийн нохой” хэмээсэн Д.Бямбасүрэнгийн үгийг “Өөрийн нохой” хэмээх дэд гарчигтаа ишлэсэн бол “Дуулиан” хэмээх өөр нэг дэд гарчигтаа “Энэ хүний шунал яасан их юм бэ, яагаад дуусдаггүй юм. Яагаад түгжилдэж хажуу дахь руугаа хутга шааж явдаг юм. Би үнэхээр ойлгохгүй байна” гэж УИХ-ын гишүүн асан Х.Тэмүүжингийн хэлснийг ишлэсэн байх жишээтэй.

Зохиогч Женкогийн тухай “Баянгол” зочид буудлын хувьцааны багцыг Монголын хөрөнгийн биржээр худалдах гэж байж. Гэвч арилжаа эхлэхээс 10 минутын өмнө тусгайлан Х.Баттулгад ямар ч өрсөлдөөнгүйгээр 44 сая төгрөгөөр зарсан байдаг. Зочид буудлаа худалдаж авангуутаа Х.Баттулга шууд зочид буудал дээр өөрийн хамгаалагчдын хамт очиж битүүмжлэн хураахад тус зочид буудлын дансанд 600 сая төгрөг бэлнээрээ байсан гээд бодоход энэ нь хувьчлал байсан уу, луйвар байсан уу гэдэг нь ихээхэн анхаарал татна” (“600 сая төгрөгтэй “сейф”-ийг 44 саяар худалдаж авсан түүх”), “1999 онд таван тэрбумын өртэй гэгдэж асан “МАХИМПЕКС”-ийг өөрийн болгов. “МАХИМПЕКС” компанийн төрийн өмчийн 51%-ийг 7,5 тэрбумаар авсан юм. 2000 онд “Талх чихэр” компанийг вант улсдаа нэгтгэв. Женко ёстой л ангайсан бүхнээ залгиж байлаа” (“Женко гэх вант улс”), “Нэг бол “MCS”, нөгөө бол “Женко”. Нэг бол Ж.Оджаргал, нөгөө бол Х.Баттулга ...Монголд дор хаяж хоёр олигархи байгаа” (“Олигархи”), “2008 оноос хойш Барилга хот байгуулалт, Зам тээврийн сайд, Хөдөө аж ахуйн сайдаар

ажиллахдаа төрийн мөнгийг завшсан, угаасан, шилжүүлсэн гэх олон дуулиант хэрэгт нэр холбогджээ. Гэвч тэдгээр нь нэг ч удаа нотлогдож, батлагдаж байсан удаагүй. Баримт нь байгаа хэрнээ гагцхүү манай гол баатарт холбоотой, эсвэл буруутай гэсэн баримт л олдож өгдөггүй зовлонтой” (“Дуулиан”), “Женко бол эх оронч, үндэсний үзэлтэй гэдэг нь маргаангүй... Женкогийн хийсэн, бүтээсэн, сэдсэн, сэтгэсэн бүхэн үндэсний бахархал, Монголын дархлааг бий болгох зорилгыг агуулдаг” (“Жинхэнэ “HERO”), “Ерөнхийлөгч асан Н.Энхбаяр нэгэнтээ “Монгол Улсад хөгжих бодлого байсаар байтал хэрэгжүүлэхгүй, хэрэгжүүлэх сонирхолгүй хэсэг хүмүүс байна. Бодлого гаргах ажилд хамгийн нөлөөтэй хүмүүс буюу Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржид энэ бодлогыг хэрэгжүүлэх сонирхол алга. Харин Х.Баттулга мэтийн гишүүдэд бол ажиллах бодол байна” гэж хэлж байв. Аргагүй дээ, тэднийг адилтгаваас ялгаагүй л чононууд. Нэг нь шархадсан чоно бол нөгөө нь ганцаардсан чоно бөлгөө” (“Ганцаардсан чоно”), Х.Баттулга “Үг дуу цөөнтэй. Гэм хор ч үл цухуйна. Гэвч холбогдсон хэргүүд, хийсэн үйлдлүүд нь яавч бага гарын “цагаан захтан”-ы үйл хэрэг биш байдаг юм... Түүнтэй холбоотой ямар ч хэрэг утаа мэт замхран алга болдог тавилантай... Даруухан зантай, даржинхан боловсролтой энэ хүн бүхнийг яаж хийв ээ. Ийм замналыг тун цөөн хүн туулдаг” (“Женко хэрхэн төгсөх бол”) гэх зэргээр бичжээ.

Уншигч та бидний өмнө нэг талаас хүн бүхэн мэдэх, нөгөө талаас нэг ч хүн үл мэдэх Женкогийн дүр урган тодорч байна. Өмөөрвөл үндэсний хөрөнгөтний төлөөлөл болсон шилдэг дүр төрх, “Тунгалаг Тамир” романы

Итгэлт баяны дүртэй адилтгаж болохуйц эх оронч гэж хэлж болох Халтмаагийн Баттулга харагдах мэт. Өөлж муулбал барж идэхгүй хулгайч, худалч, луйварчин, гэмт хэрэгтэн, зохиогчийн өөрийнх нь хэлсэнчлэн хэн ч өөрийн эрхгүй сүрдэм олзондоо шунасан арслан бар адил аймшигт мангас нүдний өмнө өндийн босч ирж байна. Халтмаагийн Баттулгад байгаа эерэг ба сөрөг талыг өрсөлдүүлэн сөргөлдүүлэн сүлжиж урлажээ. Женкогийн дүрийг тод томруун гэж хэлж болохуйц түвшинд гаргаж чадсан байна. Үүнийг уншсан цөөнгүй уншигч Монгол Улс ийм Ерөнхийлөгчтэй юмуу гэж ам ангайн гайхах болно.

“Хүйтэн цуст” капиталист гэсэн гарчигтай өөр нэг памфлет байна. Сү.Батболдын тухай аж. “Шинэ үеийн хэнээтэн”, “Бизнесийн хэнээ”, “Улс төрийн хэнээ”, “Эргэлзээтэй лидер”, “Олигархи” гэж хэн бэ?”, “Таван толгойн гол толгой”, “Оффшорын эцэг” зэрэг 11 дэд гарчигт хувааж багцалж бичжээ. “Хүйтэн цуст” капиталист хэмээх хэсэгт “Улс төр гэдэг ихэнх тохиолдолд улс эх орныхоо эрх ашгийг тэргүүнд тавьдаг хүнийг хэлдэг. Тэгвэл Сү.Батболдын хувьд тэгж хэлэхэд эндүүрэл болж мэднэ, эсвэл хэт дэгсдэж мэднэ. Учир нь өнгөрсөн хугацаанд уг хүн маань улсын ажлыг өөд нь татсан гэхээсээ илүүтэй хувийн бизнесийг өөд нь татсан гэж хэлэгддэг... “Фортуна” Батбаяр нэгэнтээ түүнээс “Таныг Ерөнхий сайд болсон хугацаанд манай улс хэр баяжсан, та өөрөө хэр баяжсан бэ” гэж асууж байж билээ” гэж зохиогч бичсэн бол “Шинэ үеийн хэнээтэн” хэмээх удаах хэсэгтээ “Сү хэзээ ч сүгсэлздэггүй. Отго жинс, лидерийн туг дарцаг хийсгээд байдаггүй. Омголон давилуун, хөөрүү биш. Чимээгүй лидер гэвэл

түүнийг л хэлнэ. Чив чимээгүй, алгуурхан гэтэх атлаа бүхнийг энэрэлгүйгээр нөмрөх сүүдэр мэт хүчирхэг нэгэн. Бизнесээс улс төрд орох өнөөгийн “хэнээрхэл” –ийг эхлүүлсэн хүн гэж түүнийг нэрлэж болно. Улс төр, бизнес хоёр сүлэлдэхийн эхний шанг татаагүй юм гэхэд хүчтэйгээр түрсэн хүн бол тэр” гэжээ.

Эх орон, хүн ардаа биш зөвхөн өөрийгөө боддог, хувиа хичээдэг хүйтэн цуст бэртэгчин буюу адилтган зүйрлэвэл аливааг шимж амьдрагч хувалзны тод томруун дүр уншигчийн өмнө тодрон гарч ирж байна. Чив чимээгүй, алгуурхан гэтэх мэт хэмээн тодотгоод энэрэлгүйгээр нөмрөх сүүдэр мэт гэжээ. Цааш нь залгуулж “Сү.Батболдыг танья гэвэл Чингис зочид буудлын хувьчлалын түүхийг сөхөх хэрэгтэй болно. Зүгээр нэг сөхөөд зогсохгүй, уг ёзоор, учир шалтгаанаас нь эхлээд бүр уудлах ёстой. Эндээс л түүний хувь хүний этик, бизнесийн мораль, улс төрийн үзэл баримтлалыг өвч бүрэн таньж мэдэж болно. “Чингис хаан” зочид буудлыг хувьчилж авсан, зарсан, эргээд хувьчилж авсан түүх бол Сү.Батболдын уран нүүдэл гэхээсээ илүүтэй, Монголын төрийг хувийн бизнестэй хэрхэн хоршуулж, хэрхэн хожиж болдгийн бэлээхэн жишээ болсон гэхэд хилсдэхгүй. Түүний дараагийн бизнес болоод улс төрийн бүх нүүдэл зөвхөн “Чингис хаан” зочид буудлын хувьчлалын түүхтэй ижил жимээр өрнөсөн байдаг нь санаандгүй давхцал гэж харагддаггүй билээ. Анзаарвал, өнгөрснөөс гэвэл Монголд ямар ч ашиг авчраагүй Бороо гоулд, өдгөөгөөс гэвэл Монголд мөн л ашиггүйгээр зарагдаж буй Тавантолгойн ордын хувь тавилан ноён Сү.

Батболдын гараар орж, “Чингис хаан” зочид буудлын замаар “будаа тээсэн”-ийг анзаарч болно” хэмээжээ.

Мөшгих сэтгүүл зүй буюу эрэн сурвалжлагч сэтгүүлчийн торгон мэдрэмж, хардах эрх эндээс нэвт мэдрэгдэж байна. Үгүйсгэхийн тулд үгүйсгэн буруутгасангүй, үндэс язгуураар нь уудалж онгичиж үзэх гэж чармайжээ.

“**Ч**ингис хаан” зочид буудлын хувьчлалыг цэвэр луйвар байсан гэх яриа амь бөхтэй оршсоор байдгийг зохиогч онцлон тэмдэглээд түүнийгээ лавшруулж “төсвийн зардлаар боссон үйлдвэр, объектууд зүгээр л нэг зээлийн гэрээгээр хувьд очиж байсны нэг нь “Чингис хаан” зочид буудал болов. Сангийн яам, Өмч хувьчлалын комисс зөвшилцөн “Чингис хаан” зочид буудлын барилгыг 15 сая ам.-доллараар үнэлж, хувьчлалын тендерийг зарласан байна. Тухайн үеийн ханшаар бол энэ нь 6,2 тэрбум төгрөг гэсэн үг л дээ. Хувьчлал явагдаж хэд хэдэн компани өрсөлдсөнөөс Сү.Батболдын “Алтай трейдинг” шалгарчээ. Гэвч шинэ эзний халааснаас мөнгө гарсангүй. Дээрх 6.2 тэрбумыг ирээдүйд төлнө гэсэн тохиролцоо л байсан юм. Энэ нь хэдийгээр тухайн үеийн нөхцөлөөр хийгдсэн хувьчлал мөн боловч ямар нэг луйвартай адил шинжүүдтэй байсан гэдгийг хэлэхгүй өнгөрч боломгүй” (“Бизнесийн хэнээ”) гэжээ.

Уг зочид буудлын барилга 1997 онд 60 хувийн гүйцэтгэлтэй, тухайн үеийн ханшаар 10 тэрбум төгрөгийн өртөгтэй байсан гэнэ. Ийм их хөрөнгийг зээлийн нөхцөлөөр өөрийн болгох боломжтой юу гэж хэн нэгэн нь асуувал хариулт нь “Огт боломжгүй” гэж гарах байв. Харин Сү.Батболд чаджээ гэсэн байна. Уг хувьчлалд шалгалт хийж зах

зээлийн бодит үнэлгээ биш байна, дахин үнэлэх хэрэгтэй гэж хоёр ч удаа УИХ-ын ажлын хэсгээс тогтоож байсан боловч УИХ үүнийг олон нийтэд танилцуулалгүй нуугаад өнгөрчээ.

“Хамгийн гайхалтай нь “Чингис хаан” зочид буудлыг Сү.Батболд хоёр удаа аваад, түүнээсээ олон удаа зарсан байдаг. Эхний удаад зээлийн гэрээгээр худалдаж аваад, эргээд төрд мөнгөөр зарчихсан гэж болно. Тэгмэгцээ Н.Энхбаярын “хаанчлал”-ын үед төрд зарсан зочид буудлаа буцаагаад өөрийн болгосон. Энд ямар технологи хэрэгжсэн бэ гэдэг асуултын хариу одоо хүртэл тодорхойгүй” хэмээн зохиогч анхааруулжээ. Сонирхолтой байгаа биз?

Төр бол хамгийн ашигтай, хамгийн том бизнес юм байна гэдгийг баттай ойлгож ухаарсан хүн бол Сү.Батболд. Тэр Монголын улс төрд Дамдины Сүхбаатарын Батболд гэсэн сурталчилгаа хэрэглэж орж ирсэн. “Ийм явган заль, нохой санааг тэр л гаргаж чадна. Тэгээд үүнийгээ алдар нэрээ хоногшуулах маркетинг гэж их цэвэрхэн нэрлэж байсан санагдаж байна” гэж номын зохиогч “Улс төрийн хэнээ” хэсэгтээ тэмдэглэжээ.

“Мэргэжилтэн, наймаачин, компанийн захирал, тэрбумтан, дэд сайд, намын дарга, Ерөнхий сайд гэх бадрангүй замналтай түүнийг улс төрд хөтөлж оруулж ирсэн хүн нь Н.Энхбаяр. “Алтай трейдинг” ХХК-ийн захирал, “Чингис хаан” зочид буудлын эзэн С.Батболдыг тухайн үеийн Ерөнхий сайд Н.Энхбаяр анх Гадаад хэргийн дэд сайдаар томилж байлаа.

Намын шинэ залуу үеэ дэмжинэ гэдэг нэрийн дор дэд сайд гэх албан тушаалыг Н.Энхбаяр бараг түүнд л зориулж бий болгосон гэлцдэг. Үнэний үртэс бий. Сү.Батболдыг дэд сайд

болсны дараа дэд сайдын албан тушаал 500 сая хүрлээ гэх цуурхал тарсан” гэж зохиогч тодотгожээ.

Сү.Батболд гэдэг хүний хөшигний цаадах үнэн бодит дүр төрхийг зохиогч алхам алхмаар тодруулж, баримтаас баримтад лавшруулан дэлгэж тавих замаар нүцгэн үнэнийг нээн үзүүлж байна. Үүнд үнэний үртэс бий гэж өөрийн санаагаа маш урнаар илэрхийлсэн байна.

“Тэр Монголын төрд гавьяа ч байгуулсан, гай ч тарьсан. Түүнийг улс төрийн өндөр албан тушаалыг мөнгөөр үнэлэх явдлын тод төлөөлөгч, сод тэргүүлэгч нь гэж үзэх хандлага бий. Өөрөөр хэлбэл, Сү.Батболдыг дэд сайдаас эхлээд Ерөнхий сайд хүртэлх төрийн өндөр сэнтийг мөнгөөр үнэ хүргэж худалдаж авсан гэх яриа тэр гэх биегүй, энэ гэх хаяггүй тэнэсээр явдаг билээ.

Баяр түүнийг залгамжлагчаараа зарлахдаа үлэмж их буюу хэдэн арван тэрбумыг авсан гэх дуулиан одоо ч амь бөхтэй оршсоор байна. С.Баяр намын даргын суудлаа Ерөнхий сайдын сэнтийтэйгээ хамт Сү.Батболдод өгөөд явсны дараахан хилийн чанадад мөнөөх С.Баярын эзэмшил бүхий долоон байшин, эдлэн газрууд илэрсэн. Үүнийг бас атаархагчдын хормойноос боссон цуу салхи гэж бодоод өнгөрч болно. Гэвч энэ салхи үнэний уулнаас эх авсан бол хожмоо улсын суурийг ч ганхуулах их хуй болж мэдэх билээ” гэжээ.

Монгол Улсын Ерөнхий сайдаар ажиллаж байсан нэр бүхий хоёр эрхэмтэй холбоотой ноцтой асуудал хөндөгдөж байна. Сү.Батболд бүхнийг мөнгөөр үнэлж худалдан авдаг хүн, тэр нь С.Баярын ашиг сонирхолтой нэгдэж нийлсэн гэжээ. Тийм яриа тэр гэх биегүй, энэ гэх хаяггүй тархсаар

эдүгээг хүргэв. Амь бөхтэй оршсоор байна. Алс холын Америкт байр байшин, эдлэн газар болон харагдаж байна. Үүнийг атаархагчдын хормойноос боссон цуу салхи гэж бодоод өнгөрч болох боловч хэрэв тэр бүхэн нь үнэний уулнаас эх авсан бол хожмоо улсын суурийг ч ганхуулах их хуй салхи болон хувирч мэднэ хэмээн сэрэмжлүүлэн анхааруулжээ. Утга агуулгын логик холбоог урамтай гоёмсгоор урлаж шаглаж илэрхийлэн гаргана гэж чухам үүнийг л хэлэх болов уу.

Д.Дамдинжав Ерөнхий сайд асан Сү.Батболдыг “Монголын баялгийн хусмыг биш өрмийг хамдаг эрхэм” гэж “Эргэлзээтэй лидер” хэсэгтээ товчхон тодорхойлоод хэдийгээр тэр өөрийгөө “Би харьцангуй цэвэр хүн” гэдэг ч үлэмж их хөрөнгө нь түүнийг “булингартуулдаг” гэжээ. Үүнтэй монголчуудын ихэнх нь санал нэгдэнэ гэдэгт эргэлзэх зүйл байхгүй. Тэр бол цэвэр биш харин туйлын бохир хүн. Эргэх цаг үе үүнийг аяндаа батлан харуулна. Үйлийн үрээс хэн ч мултарч чадахгүй.

“Сү.Батболд жирийн нэгэн ганзагачнаас төрийн бизнесийн судсыг атгасан нэгэн болсон нь бие хүний хувьд бахархалтай түүх мөн. Харин улс орны хувьд “бахархал” төрүүлэх жишиг мөн эсэхэд эргэлзэнэ” гэж зохиогч өөрийнхөө байр суурийг илэрхийлжээ. Эх орон, газар шороогоо харийнханд найр тавин зарж борлуулагчид, албан тушаал, цол хэргэмийг алт мөнгөөр үнэлж наймаалагчдыг монголын ард түмэн дэнс дэнс мөнгөөр дэлхийгээ худалддаг ноёд, уут уут мөнгөөр улсаа наймаалдаг эзэд гэж дуу шүлгэндээ цоллодогсон биш билүү.

Сү.Батболд бол барууны хүйтэн цуст капиталистуудын загварыг

Монголдоо туршиж, хамгийн сайн хэрэгжүүлсэн этгээд гэдэгт эргэлзэх юмгүй хэмээн зохиогч өгүүлээд “Бороо гоулд” компанийн үүх түүхээс өнгөцхөн боловч ончийг нь олон сөхөж “гадаадын хөрөнгө оруулагчдыг татах зорилгоор эхний таван жилд татвараас 100 хувь, дараачийн таван жилд 50 хувь чөлөөлөх хууль батлагдсан юм. Ийнхүү тэр хуулиа захиалчхаад наймаагаа хийдэг том гарын наймаачин, барууны зэрлэг капитализм гэгчийг Монголд жинхэнэ утгаар нь хэрэгжүүлэгч болж хувирлаа. Уг хуулийг хэн захиалсан бэ гэж тэр үеийн парламентын хэнээс нь ч хамаагүй асуугаарай. Бүх хариулт эргэлзээгүй нэг л хүнийг заах болно” хэмээжээ.

Юу үнэн бэ гэвэл энэ үнэн. “Ёстой л хуулийн дагуу, бүхний нүдэн дээр Монголыг тонож байсан гэж хэлж болно. “Бороо гоулд” дэндүү их ашиг олсон нь ойлгомжтой. “Бороо гоулд” компани нь 1998 оноос хойш тасралтгүй татварын болон олон хөнгөлөлт эдэлж иржээ. Хэрэв Канадын “Бороо гоулд” компани эдгээр хөнгөлөлтийг эдлэлгүй татвараа бүрэн төлж байсан бол улсын төсөвт жил бүр 160 тэрбум төгрөг, Гэнэтийн ашгийн 68 хувийн татварыг төлсөн бол жилд 10 тэрбум төгрөг төсөвт орж ирэх ёстой байлаа. 40 гаруй тонн алтны нөөцтэй гэх “Бороо гоулд”-ын орд эцэстээ нэгмөсөн хоосорч, Канадууд алтыг нь аваад авдрыг нь хаяад гарч явсан. Харин Сү.Батболд “Бороо гоулд”-ын хувьцаагаа Канадын “Сентера гоулд” –д 8 сая ам.доллараар зарчихсан, улсад тэрбум төгрөгийн татвар төлсөн гэдгээр нэр цэвэр үлдэж хоцорчээ” хэмээн “Гол тоглогч” номын зохиогч “Хүйтэн цуст” капиталист гэсэн хэсэгтээ Сү.Батболдын заль мэхийг сэртхийм тоо баримтаар сэжиглэн

илчилж бичжээ. Энэ бол Сү.Батболд гэдэг хүйтэн цуст капиталистын түмэн булхай луйврын зөвхөн ил болсон ганцхан жишээ юм.

“Тэр улс төрд орж ирснээр тэлээгүй баяжсан гэдэг бол баримт. Түүний баталгаа нь Тавантолгойн орд буюу олны хэлдэгчлэн “Нүүрсний нам” гэгчийн албан ёсны төлөөлөгч, магад үүсгэн байгуулагч нь болсон явдал. Сү.Батболд Ерөнхий сайд асан М.Энхсайхан, АМГТХЭГ-ын дарга асан Б.Жаргалсайхан нартай хамт өнөөгийн “Энержи ресурс”-ыг байгуулж байсныг өнөөдөр олон нийт сайн мэдэхгүй. Гэвч маргах аргагүй, мартах учиргүй үнэн бол энэ. Тавантолгойн ордын гол нөөцийг эзэмшиж байгаа энэ консерциум улмаар улс төрчдийг зохион байгуулалттайгаар эгнээндээ элсүүлсэн байдаг нь ч санамсаргүй хэрэг биш юм. Нэрлэвэл, Сү.Батболд, Батж.Батбаяр, Т.Бадамжунай, П.Очирбат, М.Энхсайхан, Г.Батхүү нарыг нэг халаасанд нэгтгэж, 2010 онд “Монголын майнинг корпорэйшн” нэрээр Хонгконгийн бирж дээр хувьцаа гаргаж 700 сая ам.доллар босгосон түүхтэй. Ингэж л Монголд “Нүүрсчдийн нам” гэгч нэртэй бүлэглэл бий болсон юм даа” гэж зохиогч “Нүүрсчдийн нам” хэсэгтээ сануулаад “Монголчууд тэднийг 13 гэр бүл гэж онцлон нэрлэх нь ч бий. Тэд чухам яг хэн юм бэ гэх асуулт олны анхаарлыг ихээр татдаг. Монгол Улсын Ерөнхийлөгч асан П.Очирбат, Монгол Улсын Ерөнхий сайд асан Сү.Батболд, С.Баяр, М.Энхсайхан, сайд асан С.Баярцогт, Д.Зоригт, УИХ-ын гишүүн Ч.Хүрэлбаатар, Д.Хаянхярваа, Л.Энх-Амгалан, Ж.Батсуурь, Ц.Мөнх-Оргил, бизнесмен Ж.Оджаргал, “Петровис”-ын Ж.Оюунгэрэл нарыг ерөнхийлөн эдгээрт хамааруулсаар ирсэн. Яг тэд мөн гэдгийг баараггүй тогтоочихсон баримт

бас л байхгүй. Гэхдээ УИХ-ын гишүүн Л.Энх-Амгалан “MCS”-ийн дэд захирал байхдаа “Энержи ресурс” компанийн хувьцааг 100 хувь монгол хүмүүс эзэмшдэг” гэж хэлж байсан” гэжээ. Одоо эдгээр нэрийг хэлэх зоригтон ховордсон. Монголын 30 гэр бүл гэх ерөнхий нэрс л үлдэж хоцорчээ гэж тэрбээр нэмж хэлсэн байна. Дамдинсүрэнгийн Дамдинжав сэтгүүлч ингэж хэлж чадаж байгаа нь өөрөө том зориг, том баримт юм.

“Сү.Батболдыг тэдэн дунд багтаан нэрлэдгийн хувьд бол маргаангүй мэдээлэл юм. УИХ-ын гишүүн Н.Батбаяр Сү.Батболдоос “Та Ухаа худаг”-ийн хувьцаанаас хэдэн хувь эзэмшдэг вэ?” гэж асуухад Ерөнхий сайд “Үүнийг би танд хариулах албагүй, мм-мм... гэхдээ багцаагаар 15 хувь” гэж хариулсан нь УИХ-ын чуулганы протоколд тэмдэглэгдэн үлджээ.

БНН-ын дарга Б.Жаргалсайхан хэлэхдээ “Сайд асан Сү.Батболд одоо болно оо. Шунал ихэдвэл шулам болно оо. “Чингис хаан” зочид буудлыг авсан. Бороо гоулдаас 45 тонн алт гаргасан. “Ухаа худаг”-ийн уурхайн ордыг бараг зүгээр авчихсаан. Одоо цадах хэрэгтэй” гэж бухимджээ хэмээн зохиогч өөрийн дээрх санааг баримтжуулан баталгаажуулжээ (“Нүүрсчдийн нам”).

Зохиогч барьцаа цааш нь улам лавшруулж “Монгол Улсын Ерөнхийлөгч асан Н.Энхбаяр “Монгол тулгатны 100 эрхэм” нэвтрүүлэгт оролцох үеэрээ тун ноцтой баримт дэлгэсэн. Тэрээр Сү.Батболд надтай уулзаад “Тавантолгойн ордын лицензийг эзэмшиж байгаа, энэ ордыг эргэлтэд оруулмаар байна. Энэ ордыг явуулахад улс төрийн хамгаалалт хэрэгтэй гэж үзэж байна. Т.Бадамжунай орж байгаа. Ерөнхий

сайд С.Баяр бас байгаа. АН-аас Ц.Элбэгдорж орж байгаа. Та үүнд орохгүй юм уу хэмээн санал тавьсан” гэж ярьжээ. Энэ нэвтрүүлэг олон нийтэд цацагдсанаас хойш Сү.Батболд энэ яриаг нэг ч удаа үгүйсгээгүй байгаа юм” гэсэн байна. “Үхсэн буурын толгойноос амьд ат айдаг” гэсэн мэргэн үг бий. Хөдөлшгүй үнэнийг өгүүлсэн амьд гэрч нь байгаа юм болохоор Сү.Батболд яахан үгүйсгэж чадах. Сэтгүүлч Д.Дамдинжав гогцоогоо зөв олж эрчийг нь чангаруулан атгаж чадсан байна.

Зохиогч Сү.Батболдыг Тавантолгойн “гол толгой” нь мөн гэж тодорхойлоод “Тавантолгойн анхны эзэн нь тэр. Сү.Батболд улсын хөрөнгөөр хайгуул хийгдэж, нөөц нь тогтоогдсон Тавантолгойн ордыг хэрхэн хувьдаа авсан нь мөн л хачирхалтай нууц баримт юм. Сү.Батболд Тавантолгойг хувьдаа авлаа, төрд буцааж өглөө. Уншигч авхай анзаарч байна уу? “Чингис хаан” зочид буудлын сценаритай яг адилхан байгаа биз. Тэр төрийн өмчийг энэ мэтээр хийцлэхдээ гаршсаны нотолгоо бол энэ давхцал юм... Сү.Батболд Өмнөговь аймаг дахь Тавантолгойн ордын ашиглалтын лицензийг мэдээлэлд ойр байгаа давуу эрхээ ашиглан бусдаас өмнө өрсөн эзэмшиж чаджээ” гэжээ. (“Тавантолгойн “Гол толгой”). Туйлын ноцтой баримт!

Цааш нь тэрбээр “Сү.Батболд өөрийгөө эх оронч баатар гэж хэлүүлэхийг хүсдэг байх. Гэвч үнэхээр эх орноо бодож хадгалж байсан уу, ирээдүйд үнэ хүрэхийг нь анаж байсан уу гээд жинлэвэл үнэн арай өөр талд гарч мэднэ” гэжээ. Уншигч авхай та ямар бодолтой байна? Би бол сэтгүүлч Д.Дамдинжавтай адил бодолтой байна.

“Энд эргэлзээтэй олон баримт бий. Юун түрүүнд Тавантолгойг төрд өгөөд, өөрсөддөө авч үлдсэн гэх 14 хувь нь тус ордын нийт талбайн 4 хувийг хамрах хэдий ч нөөцийнх нь 30 хувийг эзлэх гол хэсэг нь байсан гэдэг. Ухаа худаг бол Тавантолгойн нүүрсний сав газрын хамгийн их нөөцтэй, ашиглахад хамгийн хялбар хэсэг нь бөгөөд батлагдсан нөөц нь 460 сая тонн. Хамгийн гол нь эдийн засгийн үр өгөөжийн хувьд маш өндөр. Учир нь бусад хэсгээ бодвол коксжих нүүрснийх нь чанар илүү, хөрс хуулалт бага. Маш бага зардлаар их олборлолт хийх цөм хэсэг нь гэж нэрлэгддэг. “Энержи ресурс” компани энэ ордын лицензийн төлбөрт ердөө 851,8 сая төгрөг төлжээ. Батлагдсан нөөцийг нь нүүрсний хамгийн доод үнээр (70 х460 сая) тооцоход л 32 тэрбум 200 сая долларын өртөгтэй юм. Өөрөөр хэлбэл Монгол Улсын иргэн бүрт 11 сая гаруй доллар ногдох ёстой байж. Харин 2,7 сая хүний хүртэх ёстой 32 тэрбум долларын нөөцийг 20 хүрэхгүй тооны хүн хуваан хүртэх эрхтэй гэж үү” гэж зохиогч асуужээ.

Энэхүү памфлетыг Д.Дамдинжав бичиж байх цаг үед Монголын хүн ам 2.7 сая байж. Сү.Батболдын өөрийн болгосон Ухаа худаг 460 сая тонн сайн чанарын коксжих нүүрсний нөөцтэй. Нэг тонныг нь хамгийн доод үнэ буюу 70 ам.доллараар тооцож үзэхэд Монголын нэг иргэнд 11 сая гаруй ам.доллар оногдох тийм толгой эргэм хэмжээний их хөрөнгийг Сү-гээр толгойлуулсан хэдхэн тооны луйварчид хуваан дээрэмдэх эрхтэй гэж үү? Монгол Улсын Үндсэн хуульд газрын дорх баялаг Монголын ард түмний өмч гэж цагаан дээр хараар бичсэн байдаг биш бил үү? Эндээс Сү.Батболд чухам

хэн болох нь толинд тусах адил тодхон харагдаж байна.

Зохиогчийн “Хүйтэн цуст” капиталист памфлетын нэг онцгой давуу тал нь хөдөлшгүй тоо баримт, булташгүй нэр ус бүхий эрхмүүдийн нотолгоо баталгаанд нь байгаа санагдана. Дээрх тоо баримтыг дэлгэн тавихдаа “УИХ-ын гишүүн Н.Батбаяр түүнээс “Та Тавантолгойг MCS-д зарсан уу, эсвэл бэлэглэсэн үү?” хэмээн асуулт тавихад “Би Тавантолгойн лицензийг 10 гаруй жил хадгалж байгаад үндэсний компанидаа өгсөн. Хэн нэгэн гадаадын хүнд худалдаагүй” гэж хариулсан байдаг. Ингэхдээ энэ асуултад Сү.Батболд нэлээн барьц алдсаныг санаж байна. Алсуураа илт бухимдаж, уурссан байдлаа нуух гээд чадаагүй билээ” хэмээн Д.Дамдинжав онцолжээ.

Эндээс УИХ-ын гишүүн асан, бас чиг бизнесийн ухааныг муугүй мэддэг, олигархиудын муу муухайг мадаггүй гадарладаг Н.Батбаяр Сү.Батболдын эмзэг цэгийг олж хатгасан, түүнд нь цочирдож уурссан “хүйтэн цуст” капиталист хэрхэн барьц алдсаныг телевизээр харж суусан зохиогчийн дүр төрх харагдах шиг болж байна. Залгуулаад зохиогч С1-ийн “Цензургүй яриа”-гаар орсон “масктай хүн”-ий хэлснээс Тавантолгойтой хамааралтай дөрвөн баримтыг холбогдох хүмүүсийн нэр устай нь ишлэжээ.

Д.Дамдинжав сэтгүүлч Сү.Батболдыг Монгол дахь оффшорчдын “эцэг” гэж цоллоод “Оффшорын эцэг” гэсэн дэд хэсгийг бичсэн байна. Капитализмыг Монголд нэвтрүүлж, хэв шинжийг нь тээгчдийн анхдагч болсон Сү.Батболд Монголоос хамгийн түрүүнд гадаадад буюу дэлхийн хэр баргийн баян худалдаж авч хүчрэхгүй өндөр үнэтэй Лондонгийн төв гудамжинд ганган тансаг орд харштай

болсныг, мөн тэрбээр монголчууд сургийг нь ч сонсоогүй байхад харьд оффшор данс нээж мөнгөө арвижуулсныг онцлоод “Тэнд татварын дарамтаас зугтсан бизнесменүүд компаниа байгуулан бүртгүүлж үйл ажиллагаа явуулдаг. Мөн улс төрчид оффшорын бүсэд нуугдан бизнес хийж мөнгөө эргэлдүүлдэг. Эсвэл алан хядагчид, хар тамхи, зэвсгийн наймаачид мөнгөө угаадаг, нуудаг. Товчхондоо ийм” гэж тодотгоод дэлхийн бүх улс оронд улс төрчдийг, тэр тусмаа төрийн өндөр дээд албан тушаалтнуудыг оффшор бүсэд данс эзэмшихийг жигшин зэвүүцдэг гэсэн байна. Гэтэл Монголд Сү.Батболдыг жигшин зэвүүцэх бус харин УИХ-д ахин дахин сонгож өргөн мандуулдаг нь гайхалтай. Сү.Батболд энд тэнд оффшор данс нээн компаниа байгуулан үйл ажиллагаа явуулж байсан төдийгүй их хэмжээний мөнгөө эргэлдүүлсэн нь хэнд ч нууц биш юм.

Олон улсын эрэн сурвалжлах сэтгүүлчдийн консерциум Панамын баримтуудыг дэлгэхэд Монголоос 49 хүний нэр дэлгэгдсэн. Түүн дотор Сү.Батболдын ах Сү.Бат-Очирын нэр байсан. Улмаар Панамын арлуудад бүртгэлтэй оффшор данстай зарим компанийг зарлахад Монгол Улсын Ерөнхий сайд асан, УИХ-ын гишүүн Сү.Батболдын нэр бас гарч ирсэн. Английн “The Guardian” сонинд “Багамын баримтуудад илэрсэн оффшор хаягуудын нэг нь Монголын алтны компанийх бөгөөд түүний захирал нь Сүхбаатарын Батболд” гэснийг зохиогч номондоо иш татсан байна.

“Хүний хүн” гэсэн гарчигтай сонирхолтой хэсэг эл памфлет дотор байна. Сү.Батболдыг зохиогч “манай хүн” биш, “хүний хүн” гэж тодорхойлжээ. Үндэслэлийг нь үзье. “Түүний хийж

ирсэн болоод хийхээр зэхэж буй бизнесүүдэд үндэсний гэх тодотгол төдийлөн зохидоггүй. Бороогийн ордыг канадуудтай, “Скател”-ийг солонгочуудтай, Тавантолгойн ордыг хятадуудтай хамтран эзэмшдэг. Муухайгаар хэлбэл, гадаадынхантай хамсаж монголчуудаа “хомбох” бизнес эрхэлдэг. “Хомбоно” гэдэг нь монжих буюу илүүхэн ашиг хүртэх гэсэн утгатай. Сүгийн олсон хоёр долларын нэг нь гадагшаа урсаж байдаг” гэжээ. Хэтрүүлсэн дүгнэлт гэж бодохгүй байна. Харин нүдийг нь оноод хэлчихжээ. Иймэрхүү хүмүүсийн уяаг нь уртасгаж, угаадсыг нь ахиухан бэлтгэж өгөөд толгойг нь илээд байвал улс монголынхоо тусгаар тогтнолыг ч дамлахаас буцахгүй. Газар шороогоо худалдах бол бүр энүүхэнд.

Памфлетынхаа төгсгөлд Д.Дамдинжав могойг гурав таславч гүрвэлийн дайтай гэдэгчлэн Сү.Батболд өнөөдөр Монголын улс төр, бизнесийн салбарт гол тоглогч хэвээрээ байна. Түүний хүч бололцоо гэрэлд биш, сүүдэрт илүү тодордог, тэр хүслээ ил зарладаг тэнэг биш. Яг одоо бол түүний цаг. Учир нь цагийн зүүний цохилт бүр түүний эрх ашгийн төлөө эргэлдэж байна. Ул суурьтай капиталистууд өөрийн цагийг төрийн цагтай тааруулж чаддаг гэсэн философи дүгнэлт хийжээ.

Тийм байж бүрэн болно. Тэр цаг хугацаа хэр удаан үргэлжлэх бол, төгсгөл нь хэзээ яаж ирэх бол гэдэгт л хамаг учир оршино. Бурханы сургаалд бүх зүйл хоосон чанартай, үйлийн үр эргэж ирдэг гэдэг билээ.

Д.Дамдинжавын бичсэн памфлетуудаас “Женко”, “Хүйтэн цуст” капиталист” хэмээх хоёр ширхэг улс төрийн шогийг зориуд сугалан авч нарийвчилсан дэлгэрэнгүй шинжилгээ

хийлээ. Харьцуулан жишиж зэрэгцүүлж үзэж гүнзгийрүүлэн бясалгах эрхийг уншигч танд үлдээе. Хэн нь хэн бэ гэдэг нь илүү бодитойгоор тодорч харагдах буй заа. Зохиогч Монголын төр засгийг толгойлж явсан Цахиагийн Элбэгдорж, Намбарын Энхбаяр, Зандаахүүгийн Энхболд, одоо оройд нь дэрвэж яваа Ухнаагийн Хүрэлсүх, бас Цэндийн Нямдорж, Жадамбын Энхбаяр, Гомбожавын Занданшатар нарын тухай тус тус номондоо бичжээ. Өнгөрсөн үеийн төлөөлөл болгож Хорлоогийн Чойбалсангийн тухай “Монголоо мандуулсан маршал” гэсэн аятайхан хөргийг ч шигтгэж өгөхөө мартсангүй. Өчигдрийн Монгол ба өнөөгийн Монголын удирдагчдын үйл ажиллагааг харьцуулан жиших сайхан боломж олгосон байна. Өдөр, шөнө шиг зааг ялгаатай нь аяндаа мэдрэгдэнэ. Өөр ч хэд хэдэн хөрөг, памфлет номонд орсон байна. Сэтгүүлч Д.Дамдинжав эдгээр улс төрийн شوгуудаа урьд нь аль сонин хэвлэлд нийтлүүлж байсныг би мэдэхгүй юм. Нэгийг нь ч олж уншаагүй байх аж. Лав л төвийн өдөр тутмын сонинуудад гаргаагүй, голлох сониныг өдөр алгасалгүй гарчигладаг учраас ингэж хэлж байна. Нэг дор, нэг номноос шууд залгуулж уншихад надад маш хүнд байсныг нуух юун. Гол тоглогчид нь Монголоор голлож тоглогчид юм байна гэсэн хар сэтгэгдэл өөрийн эрхгүй төрж байна лээ. Уншиж

үзсэн хэнд ч “таарсан таар шуудайнууд юм даа” гэсэн бодол лавтайяа төрөх биз. Харин М.Энхболд, Т.Бадамжунай, Сахал Эрдэнэбилэг, С.Баяр, П.Очирбат, Н.Багабанди, С.Баярцогт, Ч.Сайханбилэг нарын тухай энд тусгайлсан бичлэг алга. Байсан бол сэтгэгдэл бүр ч хүндэрч гуниг харуусал улам нэмэгдэж цээж бөглөрөх байсан нь гарцаагүй. Бичээгүй нь ч болж яршиг. Амьсгаа авч байгаад сүүлд унших нь дээр биз.

«
“Гол тоглогч”-дын дүр төрх, мөн чанарыг, ялангуяа тэдний хөшигний ар дахь үнэн нүүр царайг зохиогч ончтой үг хэллэгээр оновчтойгоор ёгтлон илэрхийлж, илчлэн дэлгэж чадсан нь номын гол ололт гэж хэлье. Хошин мэдрэмж төрүүлэхүйц уран хошигнол, өнгө будаг нь зохицсон хөөрхөн зураглалууд нь памфлетыг гойд тодоор чимж, гол утга агуулгыг баяжуулж өгч байна

»

“Гол тоглогч”-дын дүр төрх, мөн чанарыг, ялангуяа тэдний хөшигний ар дахь үнэн нүүр царайг зохиогч ончтой үг хэллэгээр оновчтойгоор ёгтлон илэрхийлж, илчлэн дэлгэж чадсан нь номын гол ололт гэж хэлье. Хошин мэдрэмж төрүүлэхүйц уран хошигнол, өнгө будаг нь зохицсон хөөрхөн зураглалууд нь

памфлетыг гойд тодоор чимж, гол утга агуулгыг баяжуулж өгч байна. Жишээ нь “...Ц.Элбэгдорж намхан. Гэвч улс төрийн тэнгэр түүнд хэзээ ч өндөрдөж байгаагүй юм. Улс төрийн тайз хатуу. Ямар ч хүн тэр тайзан дээр 26 жилийн турш үзэгчдийг уйдаахгүйгээр “жүжиг” тоглоно гэдэг хэцүү” (“Сүүлчийн гавьяат жүжигчин”).

“...Шазуураа зуучихаараа тавьдаггүй “шавилхан биетэй бацаан”-ыг алх барьчихаараа ийм том дарангуйлагч болно гэж хэн санах билээ. Бөхөөр бол тэр зодог тайлах болоогүй байсан юм. Тэр ч бүү хэл, тахимаа ч

өгөх хүсэлгүй байна... ("Зэлтэрийн гацааны Зи бацаан").

"...Хотонд хоёр янзын хоточ бий. Нэг нь хотоо манадаг бол нөгөө нь хэвтрээ манадаг. Нэг нь чоно зуудаг бол нөгөө нь хүн зуудаг. Зуумтгай чанар бол түүний оршин байхын үндэс. Тиймээс л төрийнхөө хатуу чанга оосроор гинжлэн уяж, 25 жил хотоо мануулсан ганц зуудаг хоточ минь..." (Ц.Нямдоржийн тухай бичсэн "Хүн зуудаг хоточ") гэх зэргээр тус тусын дүрийн өвөрмөц онцлогийг гаргаж нээн үзүүлэхийг чармайсан байна. Мэдээж энд алдаа, оноо аль аль нь байна. Дан ганц хараар будаж муулж муучлахыг, тэрчлэн дандаа энхийн цагаан тагтаа байсан гэж магтан дөвийлгөхийн аль алийг гол зорилгоо болгоогүй байж таарна. Тухайн хүнд нэвт шингээстэй байгаа сайн ба муу, эерэг болоод сөрөг талыг, өөрөөр хэлбэл гэрэл, сүүдрийг тэнцүүхэн авч үзэхийг эрмэлзсэн нь тод мэдрэгдэж байна.

Төгсгөлд нь. Залуу сэтгүүлч Дамдинсүрэнгийн Дамдинжавын "Гол тоглогч" шинэ номын нээлт Интер-номын дэлгүүрт боллоо. Миний хувьд алсын зайнаас ажиглагчийн байр сууриар оролцов. Цөөнгүй хүн цугларчээ. МСНЭ-ийн ерөнхийлөгч Х.Мандахбаяр үг хэллээ. "Зиндаа" сэтгүүлд ажилладаг миний үзэг нэгт нөхөр Д.Дамдинжав хөрөг, памфлетын шинэ номоо гаргалаа. Манай Дамдинжав маш дуу цөөтэй. Чичилж чимхэлж татаж чангаахгүй л бол үг дуугардаггүй хүн. Төрөлх зан чанар нь энэ. Харин "Гол тоглогч" номдоо их чанга дуугарсан. Уншигчдад таашааг-дана гэдэгт итгэлтэй байгаа. Их сайн бичлэгүүд энэ номд орсон гэж өндрөөр үнэлэв.

МСНЭ-ийн дэд Ерөнхийлөгч, сэтгүүл зүй судлаач Ж.Батбаатар би

энэ номыг уншиж дуусаагүй байна. Долоо хоногийн дотор уншиж дуусгаад өөрийн үгээ хэлнэ. Би Монголын хэвлэл мэдээллийн зөвлөлд Ёс зүйн салбарыг нь хариуцдаг юм. Санал гомдол цөөнгүй ирдэг. Манай залуу сэтгүүлчид үг хэллэгээ зөв сонгож, үнэн бодит эсэхийг сайтар нягталж байх хэрэгтэй гэсэн утгатай зүйл ярив. Хашир бурхи хаяагаа манаж байна даа гэж бодогдсон.

Д.Дамдинжав "Гол тоглогч" номоо хайрт эгч Д.Жавзандулам, Д.Урангэрэл нартаа зориулжээ. Тэр хоёр эгч нь номын нээлтийн ёслолд оролцож санал бодлоо илэрхийлэв. Товчхон хоёр гурван үг хэлж шинэ номоо гаргасан дүүдээ баярлаж байна гээд алд цэнхэр хадгийг мөнгөн аягатай сүүтэй өргөн барьж байна. Дүү нь буюу "Гол тоглогч" номын зохиогч Д.Дамдинжав номынхоо тухай ярилаа. Хоёр эгчээсээ ч товчхон хоёр гуравхан үг хэлчихээд суудалдаа суучихав. Дуу цөөтэй гэдэг нь үнэхээр үнэн ажээ. Миний дэргэд сандал зэрэгцэн суусан ХИС-ийн Сэтгүүл зүйн тэнхимийн эрхлэгч, доктор Д.Дагиймаа энэ залуу чинь манай сургуулийн бүтээгдэхүүн шүү дээ. Сая албан газар нь гурван өрөө байраар шагнасан гэнэ лээ гэж тун бахархангуйгаар надад хэлэв. Тэр багш нараа, их сургуулийн хамт олноо баярлуулж чаджээ. Дуу цөөтэй хүүд хайр хүрэх шиг болсон.

"Гол тоглогч" номыг би маш анхааралтайгаар уншиж ажиглалт шинжилгээ хийх гэж оролдлоо. Хөрөг, памфлетаас бүтжээ. Эхлээд би хөргийн нэрт мастер Ш.Цэрэнпил Монголын сэтгүүл зүйд эргэж ирсэн юм биш биз, түүний хоосорсон орон зайг бөглөх шинэ авьяастан төрчихсөн юм биш байгаа гэж горьдоод шунамхайран уншив. Тэгтэл тийм биш байв. Эл номд

“Эргэж Монголдоо төрнө”, “До.Цэнджавын тэнэг шавь”, “Тэр бол бурханы “алдаа” зэрэг эвтэйхэн хөргүүд орсон ч Ш.Цэрэнпилийн алдарт “Хэнээт” шиг хөрөглөл байсангүй.

Харин “Хэнээт”-ээс ч үл дутах олон памфлет нь магнай тэнийлгэн баярлууллаа. Монголын сэтгүүл зүйн түүхэнд “Хүжийн гал”-ын Бадарч гэдэг памфлет бичигч байсан. Үгүйсгэж болохгүй. Тэгэхдээ тэдгээр нь тэр гэх эзэн биегүй, уран зохиолын шинж чанарыг илүүтэй шингээсэн бүтээлүүд байсан юм. Д.Дамдинжавынх бол тийм биш юм. Буцах хаягтай, буух эзэнтэй памфлетууд. Үүгээрээ онцгой үнэ цэнэтэй санагдана. Огт хүн барьж авч чаддаггүй ороо морь шиг тойрч зугтдаг жанрыг зориглон барьж авч, өөрийн болгож чадсан энэ хүүд баярлаж талархахаас өөр аргагүй. Бичлэг нь торгомсог, баримт нотолгоо нь үнэмшилтэй, дүр дүрслэл, зураглал нь тод гаргууд аж.

Би ерээд онд Ш.Цэрэнпилийн “Хэнээт” хөрөг найрууллыг уншиж суухдаа, Ж.Мягмарсүрэнгийн “Долоо дахь хөхний гавар буюу амьтдын тухай өгүүллэгүүд” гэдэг танин мэдэхүйн нийтлэлийн номыг уншихдаа, сүүлд Б.Ганчимэгийн сумогийн их аварга Д.Дагвадоржтой хийсэн уянгалаг ярилцлагад анализ хийж байхдаа зохиогч нарт нь учиргүй ихээр баярлан уяран хайлж монголын сэтгүүл зүй гайхамшигт уран нийтлэлчдээр тасрахгүй юм байна, юутай сайхан гэж сэтгэл цэлмэн баясч, зүрх догдлон хөөрснөө ер мартдаггүй юм. “Гол

тоглогч” номыг унших явцад яг тийм мэдрэмж ахин төрж өвгөн судлаачийн хоёр суганд жигүүр ургах шиг болов.

Д.Дамдинжав бол манай сэтгүүл зүйн салбарт өнөөг хүртэл анзаарагдаж мэдэгдээгүй явсан булаастай цул шижир алт мөн байна. Памфлетыг түүн шиг урнаар өгүүлэн зохиомжилсон нь өнөөг хүртэл нэгээхэн ч гараагүй юм. Монголын сэтгүүл зүй нэгэн цоо шинэ авьяастнаар бүл нэмлээ. Тэр тэнгэр ниргэж, цахилгаан цахих адил биднийг гайхшируулсаар монголын сэтгүүл зүйд хүч түрэн түрхрэн орж ирж байна. Ийм цаг үеийг амьд мэнд байхдаа үзэж мэдэрнэ, бүтээлүүдэд нь шүүмж бичнэ гэдэг судлаач надад ямар том баяр баясгалан билээ. Түүнийг хайрлаж хамгаалж улам бүр хөгжүүлж дэгжүүлээрэй гэж Бурхан тэнгэрт залбирах минь. Ингэхийн учир гэвэл Монголын нийгэм түүнийг талархалтайгаар алга ташин хүлээж авах нь ойлгомжтой боловч төр засгийн өндөрлөгүүд, түүний дотор олигархи бүлэглэлийнхэн, хамгийг хамж шимж залгигч хар хүчин энэ сэтгүүлчийг хажиглан гадуурхаж нухчин дарахыг оролдох нь мэдээж. Авьяас билгийг нь худалдан авч өөрсдийн бууны нохой болгож хувиргахыг хүсэмжлэх ч явдал гарах бий вий. Битгий л худалдагдаарай даа, дүү минь! Тэгвэл амьд явах ямар ч утгагүй, шал гунигтай болж хувираад мөнхийн шившигт нэр холбогдох аюул ч буй.

Улаанбаатар. 2018 оны 5, 6
дугаар сар.